

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

| № | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/ | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|------------------------------|--------------------------------|---|---|---|--|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| САЛБАР ЧИГЛЭЛ: 1 | | | | | |
| 1. Монгол Улсын хууль | | | | | |
| 1.1 | 2023.07.07 | Нийгмийн даатгалын ерөнхий хууль | <p>Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 3 дүрэм, 10 журам, 11 тогтоол, 21 тушаал, шийдвэр, 14 заавар, зөвлөмж, 11 аргачлал, чиглэл, 1 тайлбар, 8 судалгаа мэдээлэл, дээд газраас ирүүлсэн үүрэг даалгавар, чиглэл зөвлөмжийг тухай бүрт нь ажилтан албан хаагчдад хүргэж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах зорилгоор тус газрын сургалтын төлөвлөгөөнд тусгуулан сургалтыг шат дараалалтайгаар хийж ажилласан.</p> | | |
| 1.2 | 2023.07.07 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль | <p>2024 оны 01 дүгээр сараас мөрдөгдөж эхэлж байгаа хуулийн хэрэгжилтийн хүрээнд Чингэлтэй дүүргийн сар бүр дунджаар 23948 тэтгэвэр авагчдад 234,5 тэрбум төгрөгийн тэтгэврийг хугацаанд нь олгож байна. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 1435 тэтгэвэр авагчдын материалыг шинэ хуулийн</p> | | |

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

| № | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/ | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|------------------------------|--------------------------------|---|---|---|--|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| САЛБАР ЧИГЛЭЛ: 1 | | | | | |
| 1. Монгол Улсын хууль | | | | | |
| 1.1 | 2023.07.07 | Нийгмийн даатгалын ерөнхий хууль | <p>Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 3 дүрэм, 10 журам, 11 тогтоол, 21 тушаал, шийдвэр, 14 заавар, зөвлөмж, 11 аргачлал, чиглэл, 1 тайлбар, 8 судалгаа мэдээлэл, дээд газраас ирүүлсэн үүрэг даалгавар, чиглэл зөвлөмжийг тухай бүрт нь ажилтан албан хаагчдад хүргэж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах зорилгоор тус газрын сургалтын төлөвлөгөөнд тусгуулан сургалтыг шат дараалалтайгаар хийж ажилласан.</p> | | |
| 1.2 | 2023.07.07 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль | <p>2024 оны 01 дүгээр сараас мөрдөгдөж эхэлж байгаа хуулийн хэрэгжилтийн хүрээнд Чингэлтэй дүүргийн сар бүр дунджаар 23948 тэтгэвэр авагчдад 234,5 тэрбум төгрөгийн тэтгэврийг хугацаанд нь олгож байна. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 1435 тэтгэвэр авагчдын материалыг шинэ хуулийн</p> | | |

| | | | | | |
|-----|------------|--|--|--|--|
| | | | дагуу шалган хүлээн авах, ажилласан жил нэмэх болон дундаж цалин өөрчлөх 1981 тэтгэвэр авагчийн материалыг хүлээн авч өөрчлөлтийг оруулах, шинэ хуулийн тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу 103 тэтгэвэр авагчид 20% нэмэгдэл олгох, хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэврийн 1285 тэтгэвэр авагчдын сунгалт хөдөлгөөн хийх зэргээр нийт 4804 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт өөрчлөлт хийсэн байна. | | |
| 1.3 | 2023.07.07 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль | 2024 оын жилийн эцсийн байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 236,499.6 сая төгрөг батлагдсанаас 234,543.75 сая төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 14,166.18 сая төгрөг батлагдсанаас 13,042.29 сая төгрөгийн, ҮОМШӨ сангийн зардал 1,948,0 сая төгрөг батлагдсанаас 1.628,7 сая төгрөг, АДС ийн зарлага 6,374.01 сая төгрөг батлагдсанаас 6,374.01 сая төгрөг зарцуулж нийт 3.400,84 сая төгрөгийн зардал тус тус хэмнэгдэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийн дагуу зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. Сангийн зардлаас ажилгүйдлийн даатгалын сангийн зардал хэтэрч байгаа бөгөөд жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 759,9 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй бөгөөд НДЕГ-ын Бодлогын Хэрэгжилт, Судалгааны Газарт төсөвт тодотгол хийлгэх саналаа хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 1.4 | 2023.07.07 | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай | 2024 оын жилийн эцсийн байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 236,499.6 сая төгрөг батлагдсанаас 234,543.75 сая төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 14,166.18 сая төгрөг батлагдсанаас 13,042.29 сая төгрөгийн, ҮОМШӨ сангийн зардал 1,948,0 сая төгрөг батлагдсанаас 1.628,7 сая төгрөг, АДС ийн зарлага 6,374.01 сая төгрөг батлагдсанаас 6,374.01 сая төгрөг зарцуулж нийт 3.400,84 сая төгрөгийн | | |

| | | | | | |
|----------------------------------|--------------------|---|--|---------|--|
| | | | зардал тус тус хэмнэгдэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийн дагуу зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. Сангийн зардлаас ажилгүйдлийн даатгалын сангийн зардал хэтэрч байгаа бөгөөд жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 759,9 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй бөгөөд НДЕГ-ын Бодлогын Хэрэгжилт, Судалгааны Газарт төсөвт тодотгол хийлгэх саналаа хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 2. Засгийн газрын тогтоол | | | | | |
| 2.1 | 2023.11.29 №422 | “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардал төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журам” батлах тухай | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардал төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журмын дагуу 2024 оны байдлаар 12 даатгуулагчийн 4,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж шилжүүлсэн бөгөөд дээрх журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. | 947,600 | |
| 2.2. | 2023.12.13 №438 | “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам” батлах тухай | 2023 оны 12 дугаар сарын 13-ны Монгол улсын засгийн газрын 438 дугаар “ Журам батлах тухай” тогтоол болон даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журмын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөдмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 12110, жирэмсэн, амаржсаны 2029, нас барсан даатгуулагчийн гэр бүлд олгох тэтгэмж 616 ажилгүйдлийн 1779 тэтгэмжийг тус тус хуулийн дагуу баримт материалын бүрдүүлэн авч, хуулийн хугацаанд бодож, иргэд даатгуулагч нарт үйлчилгээг үзүүлж ажилласан. | | |

| | | | | | |
|-----|--------------------|--|--|--|--|
| 2.3 | 2023.12.13 №439 | “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам” батлах тухай | 2023 оны 12 дугаар сарын 13-ны Монгол улсын засгийн газрын 439 дугаар “Журам батлах тухай” тогтоол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журмын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар 110 даатгуулагчдад үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж хуулийн дагуу баримт материалын бүрдүүлэн авч, хуулийн хугацаанд тогтоон олгосон. | | |
| 2.4 | 2023.12.13 №448 | “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм” батлах тухай | 2023 оны 12 сарын 13 өдөр батлагдсан Засгийн газрын А/448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 2.3, 2.11, 2.12.1 заалтын дагуу Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын А/142 тушаалаар батлагдсан бүрэлдэхүүнээс магадлагч эмч ХБИргэдийн төлөөлөгчгүй ажилласан. 2024 онд нийт Хөдөлмөр чадвар алдалттай 314 хүнийг шинээр тогтоож, 3388 хүнийг сунгаж, 291 хүнийг цуцалж, 6 хүний хөдөлмөрийн нөхцөл сольж эрүүл мэндийн магадлалын ажил үйлчилгээг цахимаар болон шаардлагатай хүмүүсийг биечлэн ирүүлж чирэгдэлгүй шуурхай хүргэн ажилласан. | | |

| | | | | | |
|-----|--------------------|---|--|--|--|
| 2.5 | 2023.12.20 №450 | “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам” батлах тухай | <p>Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны 450 дугаар тогтоол, “ тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ын дагуу иргэд даатгуулагчийн тэтгэврийн ажилласан жил нэмүүлэх, 7-5 жилийн цалингийн дундаж өөрчлүүлэх, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэврийн хугацаа сунгуулах хүсэлтийг хууль журмын дагуу материалыг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд: 1240 иргэдийг шинэ системд хүсэлт үүсгэн шинэчилсэн хуулийн дагуу тэтгэврийг 5 жилийн цалингийн дунджаар бодож тэтгэврийг хуулийн хугацаанд тооцож шийдвэрлэсэн. Мөн тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтээ өгсөн 2620 тэтгэвэр авагчдын хүсэлтийг SICOS системд оруулан, үүнээс өндөр насны тэтгэвэр авагч 1107, цэргийн өндөр насны тэтгэвэр авагч 64, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 81, үйлдвэр ослын мэргэжлээс шалтгаалсан хөдөлмөрийн чадвар түр алдсаны 72 тэтгэвэр авагчийн ажилласан жилийн нэмэгдэл, хөдөлмөрийн чадвар түр алдсаны 1396 тэтгэврийн сунгалтыг хуулийн хугацаанд нь тэтгэврийн өөрчлөлтийг хийж, шинэчлэн тогтоосон.</p> | | |
| 2.6 | 2023.12.27 №469 | “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, “Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн дүрэм” батлах тухай | <p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн дагуу тус газар нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвөөс олгох хөрөнгө, нийгмийн даатгалын сангуудын зарлага, санхүүжилтийн талаар санхүүгийн мэдээллээр хангах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж өгөх зэргээр тус дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон баримтлан ажиллаж байна.</p> <p>“Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн дүрэм”-ийн дагуу тус газрын Нийгмийн даатгалын</p> | | |

| | | | | | |
|-----|--------------------|---|--|--|--|
| | | | <p>Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төсвийн тухай хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ дүрмийг удирдлага болгон ажиллаж байна.</p> | | |
| 2.7 | 2023.12.27 №471 | <p>“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1.5, 2.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг хэрэглэх журам”-ыг батлах тухай</p> | <p>2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч тайлант хугацаанд ажил олгогчийн нягтлан бодогчдод сургалт зохион байгууллаа. Сургалтаар ажил олгогчид даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилалыг зөв оруулах, 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн №471 тоот тушаалаар батлагдсан ҮОМШӨ-ний</p> | | |

| | | | | | |
|-----|-------------------|--|--|--|--|
| | | | даатгалын шимтгэлийн 1,5, 2,5%-аар төлөх ажил мэргэжлийн жагсаалт, ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журмын хэрэгжилтийг танилцуулан гарын авлага бэлтгэн, газрын албан ёсны фэйсбүк хуудсанд мөн нягтлан бодогчдод хэвлэж тараасан. | | |
| 2.8 | 2024.01.10 №10 | “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгоход 2024 онд итгэлцүүр тогтоох тухай | “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгоход 2024 онд итгэлцүүр тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 10-р тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |

3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал

| | | | | | |
|-----|---|---|--|--|--|
| 3.1 | Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023.12.07 №А/177, А/433 | Журам, маягтын загвар батлах тухай (Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам, Эмнэлгийн хуудасны маягтын загвар) | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/177, А/433 тушаалаар батлагдсан Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмын дагуу цахимаар болон цаасаар батлагдсан маягтын дагуу эмнэлгийн хуудсыг олгох талаар Эрүүл мэндийн төвийн эмч болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт мэдээлэл хүргэн тухай бүрт арга зүйн зөвлөгөө өгөн 38 эмнэлгийн хуудсыг цаасаар 4400 эмнэлгийн хуудсыг цахим хэлбэрээр олгосон байна. | | |
| 3.2 | 2023.12.15 №А/441, А/192 | “Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт” батлах тухай | Эрүүл мэндийн сайд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 сарын 15 өдрийн “Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийх А/441, А/192 тоот хамтарсан тушаалыг баримтлан ажиллаж байна. Энэ тушаалыг хэргжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нарт болон Өрхийн | | |

| | | | | | |
|---|------------------------------|---|--|--|--|
| | | | <p>эрүүл мэндийн төвийн эмч нарт мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс зохион байгуулсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа анхан шатны эмч нарыг чадавхжуулах” сургалтанд идэвхтэй оролцлоо.</p> <p>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон Эрүүл мэндийн төвийн даргын баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч нарын хариуцлага, мэдлэг ур чадварыг сайжруулан чадавхжуулах аян” удирдамжийн дагуу Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд 3 баг болон дүүргийн 1-24 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр явж эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль эрх зүйн дүрэм журам заалтыг танилцуулан арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.</p> | | |
| 3.3 | 2024.03.06 №А/44, А/40 | <p>“Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар”,</p> <p>“Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал” батлах тухай</p> | <p>Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар, аргачлалын дагуу маягтууд батлагдсан загвараар гарч байгаа бөгөөд гарын үсэг баталгаажилтын бүрдэлийг хянан архивын нэгж болгон хадгалж байна.</p> | | |
| 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал | | | | | |
| 4.1 | 2023.12.25 №199 | <p>“Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх” журам батлах тухай</p> | <p>Ажил олгогчоос ирсэн хүсэлтийн дагуу анхан шатны нотлох баримтыг үндэслэн “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх” журмын дагуу цалин залруулга, төрөл залруулга хийж нийгмийн даатгалын санд дутуу төлсөн шимтгэлийн дүнгээс хоногийн 0.3 хувийн алданги тооцож нийт 5,1 сая төгрөгийн алданги төвлөрүүлэн ажиллаж байна.</p> | | |

| | | | | | |
|-----|---------------------|--|--|--|--|
| 4.2 | 2023.12.25 №200 | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам, Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ, гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эхийн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ, малчин, туслах малчны нийгмийн даатгалын сайн дураар даатгуулсан тухай гэрээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээний загвар батлах тухай | НДЕГ-ын даргын 2022 оны А/200 тоот тушаалаар баталсан журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулах иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах журам, гэрээг танилцуулан гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд сайн дурын даатгалд 8100 даатгуулагч, 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 780 даатгуулагч, сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх-135 даатгуулагч, малчин, туслах малчин 12 гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамруулсан байна. | | |
| 4.3 | 2023.12.25 А/202 | “Итгэлцүүр хэрэглэх журам” батлах тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Итгэлцүүр хэрэглэх журам”-ыг газрын нийт албан хаагчдад танилцуулан, иргэд даатгуулагч, ажил олгогчдод журмын хэрэгжилттэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллах талаар сургалтыг зохион байгууллаа. | | |
| 4.4 | 2023.12.28 А/221 | “Газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг хэрэглэх журам” батлах тухай | “Газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг хэрэглэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 4.5 | 2024.03.01 №А/40 | “Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалтын журам” батлах тухай | “Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалтын журам” –ын дагуу 2024 оны 11 дүгээр сард нийт 7 байцаагчийн шалгалтанд орох материалыг хүргүүлэн ажилласан. | | |
| 4.6 | 2024.04.23 №А/87 | “Газрын доор хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд | “Газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, | | |

| | | | | | |
|---|----------------------|---|--|--|--|
| | | хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | жагсаалтыг хэрэглэх журам"-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 4.7 | 2024.05.31 №А/113 | "Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам", "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журам" батлах тухай | <p>2024 оны жилийн байдлаар 9364 аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагчдын регистрийн дугаарыг улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгаж ажилласан.</p> <p>Даатгуулагчийн үндсэн мэдээлэл, төрөл, ажил мэргэжлийн ангилал, кодыг тухай бүр шалган ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системийн нэвтрэлттэй холбоотой программ хангамжуудын эрхийн тохиргоог байцаагч, нэгж болгоноор үүсгэн шинэ системд ажиллах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Программ хангамж ашиглалт, аюулгүй байдлыг хангаж байцаагч, нэгж болгонд нууц үг, нэвтрэх нэр үүсгэсэн.</p> <p>МТТ-с зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичиг, ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу байцаагч ажилтнуудад мэдээлэн таниулж шаардлалагтай мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Шинэ системийн сургалтад тухай бүр хамрагдан нийгмийн даатгалын байгууллагын Мэдээлэл технологийн ажилтнуудын цахим мэдээлэл солилцох хуудсаар бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна.</p> | | |
| 5. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар | | | | | |
| 5.1 | | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай" 01 дүгээр албан даалгавар, Нийгмийн даатгалын | | |

| | | | | | |
|---|---------------------|--|--|--|--|
| | | №1 | ерөнхий газрын даргын “Төлөвлөгөө батлах тухай” А/138 дугаар тушаалын нийт 14 үүргийн биелэлтийг нийгмийн даатгалын байгууллагын дотоод сүлжээний Захиргаа удирдлагын газрын албан даалгаврын биелэлт хэсэгт тухай бүр байршуулан ажилласан. | | |
| 6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал | | | | | |
| 6.1 | 2023.10.24 А/139 | “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам” батлах тухай | 2024 онд тэтгэвэр тогтоолгох үндэсний сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журмын дагуу сард дунджаар 24898 тэтгэвэр авагчдыг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тэтгэвэр бодох цалинг итгэлцүүрээр өсгөн тогтоон олгож байна. | | |
| 6.2 | 2023.12.27 А/190 | “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам” батлах тухай | <p>2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч тайлант хугацаанд ажил олгогчийн нягтлан бодогчдод сургалт зохион байгууллаа.</p> <p>2024 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 5234 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн өдрийн А/190 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.</p> <p>Вэб программаар илгээсэн зөв тайлан хүлээн авах, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн</p> | | |

| | | | | | |
|-----|---------------------|--|--|--|--|
| | | | дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна. | | |
| 6.3 | 2023.10.24 A/139 | “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан)”, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт” (цахим болон цаасан), “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан), “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт” батлах тухай | “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан)”, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт” (цахим болон цаасан), “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан), “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт” батлах тухай журамд заасны дагуу шинэчлэгдсэн маягтуудыг өдөр тутмын ажилдаа хэрэглэж хэвшсэн байна. | | |
| 6.4 | 2024.01.04 №A/02 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай | Нийгмийн даатгалын сангийн 676,9 тэрбум төгрөгийн орлого, 263,1 тэрбум төгрөгийн зардлын батлагдсан төсвийг төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны жилийн 676,9 тэрбум төгрөгийн төлөвлөгөөнөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 676,9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулна гэж тооцон 263,1 тэрбум төгрөгийн зарлагын төсвөөс 259,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин төсвийн сахилга батыг ханган ажилласан. 2024 оны жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангийн 236,9 төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 6,3 сая төгрөг, | | |

| | | | | | |
|-----|---------------------|--|--|--|--|
| | | | <p>ҮОМШӨ даатаглын сангийн тэтгэмжид зарцуулсан байна. АДС-ийн тэтгэмж 0,7 сая төгрөг НДЕГ-т төсвийн тодотгол хийлгүүлэх саналаа хүргүүлсэн .</p> | | |
| 6.5 | 2024.04.02 №А/43 | Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай | <p>НДЕГ-ын даргын “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” 2024 оны А/43 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэлтсийн нийт байцаагч ажилтнуудад дотооддоо сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Уг шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажил олгогч байгууллагуудыг хамруулан Ажил олгогчдын сургалт зөвлөгөөнийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгсөн.</p> <p>Мөн газрын албан ёсны Facebook хуудас болон вэб сайт, цахим сүлжээг ашиглан ажил олгогч, иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан.</p> | | |
| 6.6 | 2024.04.24 №А/61 | 2024 оныг нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай | <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй 1956,0 сая төгрөгийн цалингийн сан бүхий 569 аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд 3417 даатгуулагчийг шинээр хамруулсан.</p> | | |

| | | | | | |
|-----|---------------------|---|---|--|--|
| | | | <p>Тус газраас иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан мэдээлэл, гарын авлага QR кодыг бэлтгэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын нэг цэгийн үйлчигээний танхимд 2. Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн газрын нэг цэгийн үйлчилгээний танхим хуулийн этгээдийн бүртгэл хэсэгт, мэдээллийн самбарт 3. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн мэдээллийн самбарт <p>Чингэлтэй Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний танхим, мэдээллийн самбарт тус тус байршууллаа</p> | | |
| 6.7 | 2024.05.02 №А/64 | Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай | <p>Чингэлтэй дүүргийн Төрийн сангийн хэлтэст шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын шаардлагатай тоон мэдээллийг хүргүүлэн хамтарч ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг улирал бүр хүргүүлж ажилласан</p> | | |
| 6.8 | 2024.05.15 №А/72 | “Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төсвийн нарийвчилсан хуваарь батлах, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахад баримтлах журам”, “Нийгмийн даатгалын сангийн | <p>Тус газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны А/72 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал”, “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөлийг</p> | | |

| | | | | | |
|----------|----------------------|--|--|--|--|
| | | төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал”, “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал” батлах тухай | аргачлалын дагуу боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 15-ны дотор 2025 оны сангийн төсөв, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. | | |
| 6.9 | 2024.05.21 №А/83 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгууллагын банкн дах дансны зарлагын гүйлгээг түр зогсоож, шимтгэл, алданги төлүүлэх “Мэдэгдэл”, дансны зарлагын гүйлгээг нээх “Зөвшөөрөл” маягтын загвар батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн №А/83 дугаар тушаалаар батлагдсан маягтын нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайланд хугацаанд батлагдсан шимтгэлийн авлага барагдуулах гэрээний дагуу төлөлт зөрчсөн ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг зогсоох талаар ажил олгогчийн захирал, нягтлан бодогчдод танилцуулж арилжааны банкнуудад мэдэгдэл хүргүүлснээр 2024 оны 4 дүгээр улиралд 18093,1 сая төгрөгийн өртэй 1342 байгууллагын харилцах дансны гүйлгээг зогсоож 248 байгууллагын 3567,7 сая төгрөгийн авлагыг барагдууллаа. | | |
| 6.1 0 | 2024.08.07 №А/139 | “Ажлын цаг ашиглалт, бүтээмж, хариуцлагыг сайжруулах” тухай | Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтыг Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 05 дүгээр сарын 24-ний өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлд “Ажил амралтын цагийн горим” бүлэг болгон оруулсан бөгөөд журмын хэрэгжилтийг тус газрын цаг бүртгэлийн системээр тогтмол бүртгэж, хүний нөөцийн мэргэжилтэн хяналт тавин ажиллаж байна. | | |

| | | | | | |
|----------|----------------------|---|---|--|--|
| | | | Тус газрын хэлтсийн дарга нар болон ажилтан, албан хаагчид ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу өдөр тутмын ажлыг хийхээс гадна, ажилтан, албан хаагчид "Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г хэлтсийн дарга нараар батлуулж, гүйцэтгэл, үр дүнг хувьчлан тооцож ажлын бүтээмжийг сайжруулан ажиллаж байна. | | |
| 6.1 1 | 2024.09.26 №А/162 | "Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх" аян зохион байгуулах тухай | Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх а/162 тоот аяны хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/64 тоот тушаалаар баталсан Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах чиглэлээр 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хамралт, орлогын хэлтсийн байцаагчдад танилцуулан Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2024 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Аяны биелэлт, тайлан мэдээг ШХУАЗГ-ын мэргэжилтэнд 2024 оны 10 сарын 18, 12 сарын 06-ны өдрүүдэд 2 удаа хүргүүлэн ажиллалаа. | | |
| 6.1 2 | 2024.10.03 №А/169 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай "Мэдэгдэл"-ийн загвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах уулзалтын тэмдэглэл"-ийн загвар, "Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ"-ний загвар, | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн №А/169 дугаар тушаалаар батлагдсан маягтын нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайланд хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 10-аас дээш сая төгрөгийн буюу их хэмжээний өртэй 10030,9 сая төгрөгийн өртэй 91 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар 4726,0 сая төгрөгийн өр авлагыг барагдуулсан. Цаашид гэрээний хугацаанд шимтгэлээ төлж барагдуулах, гэрээ зөрчсөн | | |

| | | | | | |
|---|----------------------|---|---|--|--|
| | | “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуваарь” маягтын загвар батлах тухай | тохиолдолд дараагийн шат дараалсан арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн. НДШ-ийн өр үүсгэсэн АО-ын харилцах дансны гүйлгээг түр зогсоох мэдэгдэл, уулзалтын тэмдэглэл, өр барагдуулах гэрээ, шимтгэл төлөлтийн хуваарийн маягтыг хамралт, орлогын хэлтсийн байцаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 6.1 3 | 2024.11.14 №А/205 | Улсын байцаагчийн шалгалтад орох албан хаагчдын нэрсийн жагсаалт батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн А/177 тушаалаар тус газрын нийт 8 ажилтан, албан хаагчид шалгалтад орох эрх үүсэж, Улсын байцаагчийн шалгалтад 2 албан хаагч тэнцэж, 1 албан хаагч шалгалтад ороогүй, 5 албан хаагч шалгалтад тэнцээгүй байна. | | |
| 6. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | | | | | |
| 7.1 | 2023.12.04 №8 | Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай | 2024 оны жилийн эцсийн байдлаар SICOS системд нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж нийт 616 даатгуулагчийн тэтгэмжийг хууль журмын дагуу шийдвэрлэгдэж ажилласан. | | |
| | 2024.03.05 №01 | Журам батлах тухай (Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам | Уг тогтоолын дагуу Мэдээлэл технологийн төвөөс бүх даатгуулагчдын ТДШНД-ны 2023 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдлийн мэдээллийг “Даатгуулагчид зориулсан вэб” систем, “Нийгмийн даатгал” аппликейшн, “E-Mongolia” системүүдэд байршуулсан тул даатгуулагч өөрийн мэдээллээ цахимаар харах, хянах, нэрийн дансны үлдэгдлийг хэвлэж, шалгаж өгөх зэргээр даатгуулагч иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. | | |
| 7.2 | 2023.12.04 №10 | Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын | Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай тогтоолыг хэрэгжүүлэн, 1 ор хоногт | | |

| | | | | |
|--|-------------------------------------|--|--|--|
| | сангаас олгох хэмжээг тогтоох тухай | олгох хэмжээг тогтоох тухай тогтоолыг хэрэгжүүлэн нийт 8 даатгуулагчийн 947600 төгрөгийн зардал гаргасан ба үүнээс 1 ор хоногт ногдох төлбөрийн хэмжээг 70000 төгрөгөөр тооцон 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тус газраас 1 даатгуулагчийн 490000 төгрөгийн сувиллын тусламж үйлчилгээний зардал 8 даатгуулагчийн 457600 төгрөгийн ирж очих унааны зардлуудыг тус тус тооцон олгосон байна. | | |
|--|-------------------------------------|--|--|--|

ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГА



Н. АРИУНАА

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН  Н. НАМЖИЛСҮРЭН.